

Гэрлэлтийн гэрээнд тавигдах шалгуур, шаардлага ба гадаадын зарим улсын туршлага

Мөнхбаярын ВАНЧИГМАА*

-
- I. Удиртгал
 - II. Гэрлэлтийн гэрээний онолын үндэс, түүнд тавигдах нийтлэг шалгуур
 - III. Гадаадын зарим орны туршлагаас
 - IV. Дүгнэлт, санал
-



* Дотоод хэргийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, Хууль зүйн доктор (Ph.D).



Гэрлэлтийн гэрээнд тавигдах шалгуур, шаардлага ба гадаадын зарим улсын туршлага

Мөнхбаярын ВАНЧИГМАА

Дотоод хэргийн их сургуулийн
Хууль зүйн сургуулийн Хувийн эрх
зүйн тэнхимийн ахлах багш, Хууль
зүйн доктор (Ph.D).

Хураангуй: Энэхүү өгүүлэлд гэрлэлтийн гэрээний эрх зүйн үндсэн агуулга, түүнд тавигдах нийтлэг шалгуур шаардлага болон Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн зохицуулалттай ХБНГУ, АНУ, Япон, Франц зэрэг улсын гэрлэлтийн гэрээний эрх зүйн туршлагыг харьцуулан шинжилж, гэрлэлтийн гэрээний хүчин төгөлдөр байдал, гэрээний чөлөөт байдал ба шударга байдлын шалгуур, гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг голчлон авч үзсэн болно. Судалгааны үр дүнд Монгол Улсад энэхүү институтийг боловсронгуй болгоход чиглэсэн шаардлагатай эрх зүйн орчныг сайжруулах санал дэвшүүлэв.

Түлхүүр үг

гэрлэлтийн гэрээ, гэр бүлийн эрх зүй, хөрөнгийн харилцаа

I. УДИРТГАЛ

Гэрлэлтийн гэрээ нь гэрлэгчдийн эд хөрөнгийн болон зарим эрх, үүргийн харилцааг урьдчилан зохицуулах эрх зүйн механизм юм. Орчин үеийн нийгэмд хөрөнгийн бүтэц, бизнесийн оролцоо, олон улсын гэр бүлийн харилцаа өсөн нэмэгдэж байгаа нь гэрлэлтийн гэрээний ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна. Монгол Улсад гэрлэлтийн гэрээний талаарх ойлголт харьцангуй шинэ бөгөөд практикт өргөн хэрэглэгддэггүй. Гэвч хөрөнгийн маргаан, гэр бүл цуцлалтын статистик өсөж буй нөхцөлд энэхүү институтын судалгаа онол, практикийн ач холбогдолтой болж байна. Энэхүү өгүүллийн зорилго нь гэрлэлтийн гэрээний үндсэн шалгуур шаардлагыг тодорхойлох, олон улсын туршлагыг харьцуулан шинжлэх, Монгол Улсын эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал дэвшүүлэхэд оршино.

II. ГЭРЛЭЛТИЙН ГЭРЭЭНИЙ ОНОЛЫН ҮНДЭС, ТҮҮНД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШАЛГУУР

Гэрлэлтийн гэрээ нь иргэний эрх зүйн хэлцлийн төрөлд хамаарах боловч гэр бүлийн эрх зүйн онцлог шинжийг агуулдаг. Энэ нь зөвхөн эд хөрөнгийн асуудлыг



зохицуулах бус, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, ирээдүйн маргаанаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Эрх зүйн онолын хувьд гэрлэлтийн гэрээг "эрх зүйн урьдчилан сэргийлэх механизм" гэж үздэг. Учир нь талуудын өмчийн харилцааг урьдчилан тодорхойлсноор гэр бүл цуцлалтын үед үүсэх маргааныг багасгадаг.

Ром-германы эрх зүйн тогтолцоонд гэрлэлтийн гэрээг өмчийн дэглэм сонгох хэрэгсэл гэж үздэг бол англо-саксоны эрх зүйд талуудын эрх чөлөөт тохиролцооны илэрхийлэл гэж тайлбарладаг. Сүүлийн жилүүдэд олон улсын шинжтэй гэр бүлийн харилцаа өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор гэрлэлтийн гэрээ нь олон улсын хувийн эрх зүйн судалгааны чухал объект болж байна. Ялангуяа өөр өөр улсын иргэдийн гэрлэлтийн үед аль улсын хууль хэрэглэх асуудал практикт түгээмэл тулгарч байна.

Гэрлэлтийн гэрээ нь дараах үндсэн чиг үүрэгтэй

1. Өмчийн эрхийг хамгаалах;
2. Бизнесийн эрсдэлийг бууруулах;
3. Өв залгамжлалын асуудлыг тодорхой болгох;
4. Гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалах;
5. Шүүхийн ачааллыг бууруулах.

Иймд энэхүү институт нь зөвхөн гэр бүлийн хүрээний асуудал бус эдийн засаг, иргэний эдийн засгийн үр дагавартай эрх зүйн шилжилт хөдөлгөөнийг саадгүй, түргэн шуурхай эргэлтийн тогтвортой байдалтай холбоотой чухал ач холбогдолтой гэж ойлгож болох юм. Гэрлэлтийн гэрээний ач холбогдол болон хууль зүйн хүрээнд хүчин төгөлдөр хэрэгжих баталгааг хангах зорилгоор тодорхой шаардлага тавигддаг. Эдгээр шаардлага нь үндэсний хууль тогтоомж болон олон улсын жишигт нийтлэг байдлаар тусгагдсан байх зүйтэй. Үүнд:

Нэгдүгээрт, сайн дурын үндсэн дээр байгуулагдсан байх шаардлагатай. Хэрэв талуудын аль нэг нь дарамт шахалт, айлган сүрдүүлэлт, хуурч мэхлэх замаар гэрээнд гарын үсэг зурсан бол уг гэрээ хүчин төгөлдөр бус болох боломжтой.

Хоёрдугаарт, талууд бүрэн эрх зүйн чадамжтай байх ёстой. Насанд хүрээгүй болон эрх зүйн чадамжгүй этгээдийн байгуулсан гэрээ нь хууль зүйн үр дагаваргүй гэж үзэх үндэслэлтэй.

Гуравдугаарт, гэрээний агуулга хууль болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн байх шаардлагатай. Хүүхдийн тэтгэлэг төлөхөөс татгалзах, гэр бүлийн хүчирхийллийг зөвтгөх, хүний эрхийг ноцтой хязгаарлах нөхцөл нь хүчин төгөлдөр бусад тооцогддог.

Дөрөвдүгээрт, хэлбэрийн шаардлага хангах ёстой. Ихэнх улсад гэрлэлтийн гэрээг бичгээр байгуулж, нотариатаар баталгаажуулахыг шаарддаг.

Тавдугаарт, шударга байдлын зарчим чухал байр суурь эзэлдэг. АНУ болон Европын зарим орны практикт гэрээ нь нэг талд илт давуу байдал олгосон бол шүүхээс хүчингүй болгох боломжтой байдаг. Тэдгээр шаардлага нь талуудын тэнцвэртэй байдлыг хангахын зэрэгцээ гэр бүлийн эрх зүйн хамгаалалтын механизмыг бүрдүүлдэг.



Судалгаанаас харахад иргэдийн дийлэнх нь гэрлэлтийн гэрээг "итгэлцэлгүй байдлын илрэл" гэж ойлгодог нь хэрэглээг бууруулж байгаа нэг том хүчин зүйл гэж ойлгож болохоор байна. Мөн нотариат, өмгөөлөгчдийн практик нэгдмэл бус байдал асуудал үүсгэдэг.

Практикаас харахад Монгол Улсад дараах асуудал тулгамдаж байна: Үүнд:

- гэрээний загвар, аргачлал дутмаг;
- шүүхийн практик тогтворжоогүй;
- гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалах зохицуулалт сул;
- олон улсын гэрлэлтийн харилцааны зохицуулалт хангалтгүй;
- өмчийн үнэлгээ, мэдээллийн ил тод байдал сул.

Ялангуяа бизнесийн хөрөнгө, хувьцаа, оюуны өмчтэй холбоотой харилцаанд гэрлэлтийн гэрээний ач холбогдол өсөн нэмэгдэж байна. Иймд Монгол Улс гадаадын туршлагыг үндэсний онцлогт нийцүүлэн нэвтрүүлэх шаардлагатай байна.

Гэрлэлтийн гэрээний талаарх орчин үеийн чиг хандлага нь зөвхөн өмчийн харилцааг бус, бизнесийн оролцоо, хөрөнгө оруулалт, олон улсын эрх зүйн харилцаатай уялдан хөгжиж байна. Судлаачид гэрлэлтийн гэрээг ирээдүйн маргааныг бууруулах хамгийн үр дүнтэй урьдчилан сэргийлэх механизмын нэг гэж үздэг. Практикт гэрээний хүчин төгөлдөр байдлыг үнэлэхдээ шүүхүүд талуудын тэнцвэртэй байдал, мэдээллийн ил тод байдал, сайн дурын зарчмыг онцгой анхаардаг. Энэ нь гэр бүлийн эрх зүйн хамгаалалтын үндсэн зорилготой холбоотой.

Монгол Улсад энэхүү институтын талаарх онолын болон практик судалгааг нэмэгдүүлэх шаардлагатай хэвээр байна. Ялангуяа олон улсын гэрлэлт, бизнесийн хөрөнгөтэй холбоотой маргаан өсөн нэмэгдэж байгаа нөхцөлд гэрлэлтийн гэрээний хэрэглээ цаашид өсөх төлөвтэй байна. Сүүлийн 2020–2024 оны статистик үзүүлэлтээс харахад Монгол Улсад жилд дунджаар 14–17 мянган гэрлэлт бүртгэгдэж¹, 3,300–4,700 орчим гэр бүл цуцлагдаж байна.² Харин гэрлэлт хүчин төгөлдөр бус гэж тооцогдсон хэргийн тоо маш бага буюу нийт гэрлэлтийн 0.05–0.17 хувийг эзэлж байгаа нь гэр бүлийн давхардсан бүртгэл албан ёсоор бага түвшинд бүртгэгдэж байгааг харуулж байна³ Гэхдээ энэхүү үзүүлэлт нь бодит байдалд давхардсан бүртгэл байхгүй гэсэн дүгнэлт хийх үндэслэл болохгүй. Учир нь гэрлэлтийн бүртгэлийн мэдээллийн сангийн уялдаа, бүртгэлийн хяналтын механизм, ялангуяа гадаад улстай холбоотой гэрлэлтийн бүртгэлийн нэгдсэн систем хангалтгүй байгаагаас шалтгаалан зарим тохиолдолд давхардсан бүртгэл илрэхгүй байх эрсдэл оршиж байна. Мөн шүүхийн практикт гэрлэлт хүчин төгөлдөр бус гэж тооцох хэрэг цөөн байгаа нь иргэд уг эрх зүйн хамгаалалтыг хангалттай ашиглахгүй байгаатай холбоотой байж болох юм. Иймээс гэр бүлийн давхардсан бүртгэлийг бууруулахад зөвхөн хууль

¹ Үндэсний статистикийн хороо. Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2021–2024. УБ, 128 дахь тал.

² Монгол Улсын Дээд шүүх. Иргэний болон гэр бүлийн хэргийн статистик тайлан. (Улаанбаатар: 2023), 87 дахь тал.

³ Зохиогчийн тооцоолол.

зүйн зохицуулалт бус, бүртгэлийн мэдээллийн системийн интеграц, хяналтын механизмыг боловсронгуй болгох шаардлагатай байна. Цаашлаад гэрлэлтийн гэрээ зөвхөн талуудын хооронд үйлчлэх үү, эсвэл үл хөдлөх хөрөнгө, хувьцаа, банкны барьцаа зэрэг гуравдагч этгээдийн эрхтэй огтлолцох үед бүртгэлээр ил тод болсон нөхцөлд л эсэргүүцэх үү гэдэг нь практикт чухал ач холбогдолтой байна:

Зураг 1. Гэр бүлийн давхардсан бүртгэл

Гэр бүлийн давхардсан бүртгэл (шууд бус үзүүлэлтээр), Монгол Улс – Сүүлийн 5 жил

Он	Гэрлэлт (нийт)	Гэр бүл цуцлалт	Гэрлэлт хүчин төгөлдөр бус (шүүх)	Боломжит давхардсан бүртгэлийн эрсдэл (%)
2020	~17,500	~3,300	25	0.14%
2021	~17,400	~3,390	9	0.05%
2022	~17,500	~4,553	~20	0.11%
2023	~16,100	~4,776	~22	0.13%
2024	14,225	4,436	~25	0.17%

Судалгаанаас үзвэл орчин үеийн гэр бүлд хөрөнгийн бүтэц улам олон төрөлтэй болж түүнийг дагаад гэр бүлийн хэлбэр, гэр бүл болох зорилго ч өөр өөр болж байна. Ерөнхийд нь загварчлан дараах байдлаар харвал

А. Эдийн засгийн үр өгөөжийг эрхэмлэн гэр бүл үүсгэх

Б. Эрх, ашиг сонирхлоо дээрдүүлэх буюу гэрлэлтэд үндэслэж эрх олж авах

Эдийн засгийн үр өгөөжийг эрхэмлэн гэр бүл үүсгэх: Зарим хүмүүс гэр бүл болох, гэр бүлийн гишүүн хамтрагчаа сонгох үндэслэлийг эдийн засгийн үр ашиг, өгөөжийг үндэслэн сонгож хамтын хөрөнгө оруулалт, үл хөдлөх хөрөнгө, хадгаламж, компанийн хувьцаа, крипто болон цахим хөрөнгө, гадаад дахь орлого, бизнесийн эрсдэл, хамтын зээл зэрэг хэрэгцээ шаардлага зорилго нь уламжлалт "орон байр, гэр ахуйн эд зүйл" гэсэн ойлголтоос давж гарсан. Ийм төрлийн ашиг сонирхол, эдийн засгийн үр өгөөжийг эрхэмлэн үндэслэсэн гэр бүлийн харилцаанд хууль зүйн ерөнхий зохицуулалт төдийлөн хангалттай зохицуулалтыг хийж тэр харилцаанаас урган гарч буй гэр бүлийн харилцаанд өртөгдөж буй бүхий л эрх ашгийг түүнчлэн хүүхдийн эрхийг хамгаалж чадахгүй байх нь ч нийтлэг байна. Гэрлэлтийн гэрээ нь гэрлэлтийг арилжааны хэлцэл болгон хувиргах ёсгүй. Харин гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг шударгаар урьдчилан тогтоох, талуудын хүлээлтийг нийцүүлэх, хүүхдийн үндсэн эрх, эдийн засгийн хэрэгцээ шаардлагыг ямар ч тохиолдолд тасалдуулахгүй байх болон эдийн засаг эрх зүйн байдал сул талын хамгаалалтыг баталгаажуулах эрх зүйн хэрэгсэл байх ёстой.

Эрх, ашиг сонирхлоо дээрдүүлэх буюу гэрлэлтэд үндэслэж эрх олж авах: Мөн нийгмийн хэрэгцээ шаардлага, хөгжлийг дагаад сурч боловсрох, амьдрах,



эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор гадаад улсад амьдрах оршин суух эрх авах, эсхүл гадаад улсын иргэдийн манай улсад амьдран суух бүхий л эрх зүйн таатай нөхцөлийг бүрдүүлэх зэргээр гэр бүлийн харилцаа үүсгэх нь нийтлэг болоод байна. Энэ үед Монгол Улсын иргэн гадаадын иргэнтэй гэрлэх, эсхүл гэрлэгчид гадаадад амьдрах, хөрөнгө нь өөр өөр улсад байрлах нөхцөл нэмэгдэх тусам хэрэглэх хууль, шүүхийн харьяалал, гэрээний хүчин төгөлдөр байдал чухал болно.

Шинэчилсэн найруулгын төсөлд гэрлэгчдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүргийг гэрлэлтийн гэрээнд тохиролцсон улсын хууль тогтоомжийн дагуу тодорхойлж болох санаа тусгагдсан нь энэ чиглэлийн эрх зүйн зохицуулалтын хувьд ахицтай алхам юм.⁴ Гэхдээ хэрэглэх хуулийг сонгох заалт нь Монгол Улсын нийтийн журам, хүүхдийн эрх ашиг, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, тэтгэмжийн доод баталгаа зэрэг императив зохицуулалтыг тойрч гарах арга хэрэгсэл болох ёсгүй. Иймээс олон улсын гэрлэлтийн гэрээнд тусгайлан тайлбарлах, баталгаажуулах, орчуулга, нотариат, бүртгэлийн шаардлагыг тодорхой болгох зайлшгүй шаардлагатай.

Шинээр боловсруулагдаж буй хууль тогтоомжийн суурь судалгаа болон хуулийн төслөөс үзвэл Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гэрлэлтийн гэрээнд тогтмол хамтран амьдарсан орон байрнаас бусад дундын эд хөрөнгийн эрх, үүргийг хуваах, хуваарьт хөрөнгийг тодорхойлох, гэрлэлт дуусгавар болсны дараах эд хөрөнгийн эрх, үүргийг тогтоох, гэр бүлийн хэрэгцээний зардлыг хуваарилах зэрэг агуулгыг тусгаж болохоор заасан.⁵ Энэхүү жагсаалт нь гэрлэлтийн гэрээг зөвхөн эд хөрөнгийн харилцаанд төвлөрүүлэх чиглэлтэй бөгөөд Монголын эрх зүйн орчинд тохиромжтой эхлэл гэж судлаачийн хувьд харж байна. Гэрээнд гэрлэхээс өмнөх хөрөнгө, гэрлэлтийн явцад бий болох орлого, бизнесийн хөрөнгө, өр төлбөрийн зориулалт, гэр бүлийн амьдралын ердийн зардал, хүүхдийн хэрэгцээнд зориулсан хуримтлал, зээлийн хариуцлага, гэрлэлт дуусгавар болбол эд хөрөнгийг үнэлэх аргачлал зэргийг тусгаж болно. Мөн гэрлэгчдийн аль нэг нь гэр бүлийн хэрэгцээнд зориулан ажил, орлогоосоо татгалзсан тохиолдолд нөхөн хамгаалах эд хөрөнгийн зохицуулалт байх ч нэн чухал юм.

Гэрлэлтийн гэрээнд тавигдах нийтлэг шаардлага байдлаар урьдчилан хүүхдийн эрх ашигт харш байдлаар шийдэх, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн этгээдийн эрхээ хамгаалуулах боломжийг хязгаарлах, гэрлэгчдийн хөдөлмөр эрхлэх, суралцах, нийгмийн харилцаанд оролцох эрхийг хориглох заалтыг хүчин төгөлдөр бус гэж шууд заах нь эрх зүйн ач холбогдолтой зохицуулалт болж байгааг ч дурдах нь зүйтэй.⁶

Цаашлаад гэрлэлтийн гэрээний маргааныг шийдвэрлэхдээ шүүхийн хяналт ч хоёр түвшинтэй байх шаардлагатай гэж үзэж байна. Нэгдүгээрт, гэрээ байгуулах үеийн хүсэл зориг чөлөөтэй байсан эсэх, мэдээлэлтэй сонголт хийсэн эсэх, нэг талын эдийн засгийн хэт давуу байдлыг ашигласан эсэхийг шалгана. Хоёрдугаарт,

⁴ Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, 2024 он.78.1–78.2.

⁵ ГБТХ-ийн шинэчилсэн найруулгын төсөл, 23.1.1–23.1.4.

⁶ ГБТХ-ийн шинэчилсэн найруулгын төсөл, 23.2.1.



гэрээг хэрэгжүүлэх үеийн үр дагавар хэт шударга бус болсон эсэхийг үнэлнэ. Учир нь гэрээ байгуулах үед тэнцвэртэй байсан тохиролцоо олон жилийн дараа хүүхэд төрөх, өвчин тусах, хөдөлмөрийн чадвар алдах, гэр бүлийн хүчирхийлэл, бизнесийн эрсдэл зэрэг шалтгаанаар нэг талд хэт дарамттай болж болзошгүй юм.

Цөөн тохиолдол гарч байгаа гэрлэлтийн гэрээ нь хүчин төгөлдөр бус болох тохиолдол ч гарч байгааг анхаарч энэ төрлийн гэрээнд тавигдах шаардлагыг боловсронгуй болгох жишиг загвар тогтоох нь онол практикийн хувьд өндөр ач холбогдолтой. Гэрлэлтийн гэрээ нь иргэний эрх зүйн хэлцлийн нэг төрөлд хамаарах тул хүчин төгөлдөр байдлын ерөнхий шаардлагыг хангах ёстой. Хэрэв хуульд заасан шаардлагыг хангаагүй бол уг гэрээг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүчин төгөлдөр бус гэж тооцох боломжтой. Монгол Улсын Иргэний хууль болон олон улсын шүүхийн практикт дараах үндэслэлүүд түгээмэл хэрэглэгддэг байна.

Сайн дурын бус хэлцэл: Талуудын аль нэг нь дарамт шахалт, айлган сүрдүүлэлт, хуурч мэхлэх, төөрөгдүүлэх замаар гэрээнд гарын үсэг зурсан тохиолдолд гэрээ хүчин төгөлдөр бус болох үндэслэл бүрдэнэ. Гэрээний үндсэн зарчим нь талуудын чөлөөт хүсэл зориг байдаг бөгөөд хүсэл зориг гажуудсан тохиолдолд хэлцлийн хүчин төгөлдөр байдал алдагддаг.

АНУ-ын шүүхийн практикт гэрлэхээс хэдхэн хоногийн өмнө эд хөрөнгийн дарамт үзүүлж байгуулсан "Prenuptial Agreement"-ийг хүчингүйд тооцсон тохиолдол цөөнгүй байдаг. Ийм төрлийн шалгуур жишиг нь гэр бүлийн эрх зүйд талуудын бодит тэгш байдлыг хамгаалах зорилготой байдаг байна.

Хэт шударга бус буюу нэг талд илт давуу нөхцөл: Гэрээ нь нэг талын эрх ашгийг хэт давамгайл хамгаалсан, нөгөө талын эдийн засаг болон эрх зүйн байдал бусад эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарласан бол шүүхээс хүчингүйд тооцох боломжтой. Европын зарим улсын шүүхийн практикт амьжиргааны баталгаагүй үлдээх, бүх хөрөнгөөс бүрэн татгалзуулах зэрэг нөхцөлийг нийтийн ашиг сонирхолд харшилсан гэж үздэг. Германы Холбооны Дээд шүүхийн практикт эдийн засгийн хувьд сул талтай эхнэр, нөхрийн эрхийг хамгаалах зарчим чухал байр суурь эзэлдэг. Ялангуяа хүүхэд асрах үүрэгтэй этгээдийн эрхийг ноцтой зөрчсөн нөхцөлийг хүчин төгөлдөр бус гэж үзэх хандлага түгээмэл байна.

Хууль болон нийтийн ашиг сонирхолд харшилсан нөхцөл: Гэрлэлтийн гэрээ нь хүний үндсэн эрх, хүүхдийн эрх ашиг, нийтийн дэг журамд харшилж болохгүй. Тухайлбал:

- хүүхдийн тэтгэлгээс татгалзах;
- гэр бүлийн хүчирхийллийн хариуцлагыг үгүйсгэх;
- хувийн эрх чөлөөг хэт хязгаарлах;
- хууль бус үйл ажиллагааг зөвшөөрөх зэрэг нөхцөлийг шүүх хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэлтэй.

Монгол Улсын Иргэний хуулийн дагуу хууль зөрчсөн хэлцэл хүчин төгөлдөр бус байх бөгөөд энэ нь гэрлэлтийн гэрээнд нэгэн адил хамаардаг.



Хэлбэрийн шаардлага хангаагүй байх: Олон улсын жишигт гэрлэлтийн гэрээг бичгээр байгуулж, нотариатаар баталгаажуулах шаардлага тавьдаг. Хэрэв энэхүү шаардлагыг хангаагүй бол гэрээ хүчин төгөлдөр бус болох эрсдэлтэй. Франц болон Герман улсад нотариатын баталгаажуулалт нь зөвхөн хэлбэрийн төдийгүй талуудын эрх ашгийг хамгаалах урьдчилан сэргийлэх механизм гэж үздэг.

Дүр үзүүлэн буюу халхавчилсан хэлцэл: Практикт зарим тохиолдолд гэрлэлтийн гэрээг өөр зорилгыг халхавчлах хэрэгсэл болгон ашиглах тохиолдол гардаг. Ийм нөхцөлд шүүх хэлцлийн бодит зорилгыг тогтоож, хүчин төгөлдөр бус гэж үзэх боломжтой. Монгол Улсын шүүхийн практикт дүр үзүүлэн хийсэн хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзсэн тохиолдол бий. Тухайлбал, ... 132/ШШ2023/00212 дугаар шийдвэрт шүүх бодит хүсэл зоригийг тодорхойлж, халхавчилсан хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцсон нь гэрлэлтийн гэрээний маргаанд мөн адил хэрэглэгдэх боломжтой онолын үндэслэл болж байна.

Хөрөнгийн мэдээллийг нуун дарагдуулсан байх: АНУ болон Европын орнуудын практикт гэрээ байгуулах үед талууд хөрөнгө, өр төлбөрийн талаарх үнэн зөв мэдээллээ бүрэн гаргах үүрэгтэй гэж үздэг. Хэрэв нэг тал хөрөнгөө санаатайгаар нуун дарагдуулсан бол гэрээ хүчин төгөлдөр бус болох боломжтой. Энэ шаардлага нь гэрээний шударга, тэнцвэртэй байдлыг хангахад ач холбогдолтой.

Ийнхүү гэрлэлтийн гэрээ хүчин төгөлдөр бус болох үндэслэл нь зөвхөн хэлбэрийн шаардлагаар хязгаарлагдахгүй бөгөөд талуудын бодит хүсэл зориг, шударга байдал, нийтийн ашиг сонирхол, хүүхдийн эрхийн хамгаалалттай нягт холбоотой байна. Харьцуулсан эрх зүйн судалгаанаас үзэхэд орчин үеийн чиг хандлага нь гэрээний эрх чөлөөг эрхэмлэхийн зэрэгцээ нийгмийн эмзэг эрх ашгийг хамгаалах хяналтыг чангатгах хандлагатай байна.

III. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГААС

ХБНГУ-ын туршлага: ХБНГУ-ын Иргэний хуульд гэрлэлтийн гэрээний зохицуулалт нэлээд боловсронгуй хийгээд нарийвчлалтай зохицуулагдсан байдаг. Герман Улсад талууд гэрлэлтийн өмнө болон гэрлэлтийн хугацаанд өмчийн хуваарилалт буюу захиран зарцуулалт хийх байдлыг харилцан тохиролцох замаар сонгох эрхтэй.

Германд нийтлэг хэрэглэгддэг дэглэм нь "Zugewinnngemeinschaft" буюу хамтын өсөлтийн дэглэм⁷ юм. Энэ тохиолдолд гэрлэлтийн хугацаанд олсон хөрөнгийн өсөлтийг гэр бүл цуцлах үед хуваадаг. Энэ нь талууд гэрлэлтийн гэрээгээр:

- өмчийн тусгаарлалт;
- өмчийн хамтын дэглэм;

⁷ Германы "Zugewinnngemeinschaft" дэглэмд:

· гэрлэгчид тус тусын өмчөө бие даан эзэмшинэ;
· гэрлэлтийн хугацаанд ч өмч автоматаар "хамтын өмч" болохгүй;
харин гэр бүл цуцлах үед хөрөнгийн өсөлтийн зөрүүг тооцож тэнцүүлдэг...Alexy, Lennart; Fisahn, Andreas; Hähnchen, Susanne; Mushoff, Tobias; Trepte, Uwe. *Das Rechtslexikon. Begriffe, Grundlagen, Zusammenhänge*. 2. Auflage. Bonn: J.H.W. Dietz Nachf., 2023, 93.



- орлогын хуваарилалт;
- өв залгамжлалын асуудлыг зохицуулж болно.

Германы Холбооны Дээд шүүхийн практикт гэрээний эрх чөлөөний зарчим, шударга байдлыг онцгой анхаардаг. Ялангуяа жирэмсэн эмэгтэй эсвэл эдийн засаг, эрх зүйн байдлын хувьд хараат этгээдийг хохироосон нөхцөлийг хүчингүй болгох тохиолдол бий. Энэ нь гэрээний эрх чөлөө болон нийгмийн хамгааллын тэнцвэрийг хадгалах зорилготой юм.

АНУ-ын туршлага: АНУ-д гэрлэлтийн гэрээг "Prenuptial Agreement" гэж нэрлэдэг бөгөөд өргөн хэрэглээтэй эрх зүйн институт юм. Муж улс бүр өөрийн зохицуулалттай боловч Uniform Premarital Agreement Act (UPAA) нь нийтлэг загвар болж хэрэглэгддэг.

АНУ-ын практикт дараах асуудлыг онцгой авч үздэг:

- хөрөнгийн бүрэн мэдээлэл өгсөн эсэх;
- гэрээ байгуулах үед хуульчийн зөвлөгөө авсан эсэх;
- нэг талын эрх ашиг хэт давамгайлсан эсэх;
- гэрээ байгуулах хугацаа, нөхцөл.

Практикт бизнес эрхлэгчид, өндөр орлоготой иргэд, олон улсын хөрөнгөтэй хүмүүс гэрлэлтийн гэрээг өргөн ашигладаг. АНУ-ын шүүхүүд гэрээний шударга байдлыг "unconscionability" буюу хэт шударга бус байдлын шалгуураар үнэлж дүгнэлт гаргадаг.

Япон болон Францын туршлага: Япон Улсад гэрлэлтийн гэрээг Иргэний хуульд зохицуулдаг боловч хэрэглээ харьцангуй бага байдаг. Япон соёлд гэр бүлийн итгэлцлийг чухалчилдагтай холбоотойгоор гэрлэлтийн гэрээг заримдаа сөргөөр ойлгох хандлага түгээмэл байдаг байна. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд олон улсын гэрлэлт болон хөрөнгийн маргаан өссөнөөр энэхүү гэрээний хэрэглээ ч нэмэгдэж байна.

Франц Улсад гэрлэлтийн гэрээ нь нотариатын тогтолцоотой салшгүй холбоотой. Талууд гэрлэхээс өмнө өмчийн дэглэмээ сонгож, нотариатын өмнө баталгаажуулдаг. Францын туршлагаас харахад урьдчилан тодорхой, мэргэжлийн түвшинд боловсруулсан гэрээ нь гэр бүл цуцлалтын маргааныг эрс бууруулдаг давуу талтай гэж үздэг байна.

БНСУ-ын туршлага: БНСУ-ын Иргэний хуульд гэрлэлт үүсэхээс өмнө эд хөрөнгийн харилцааны талаар өөрөөр тохиролцоогүй бол хуульд заасан дэглэм үйлчлэх, гэрээ байгуулсан бол гэрлэлтийн явцад өөрчлөхийг хязгаарлах, гуравдагч этгээдэд эсэргүүцэхийн тулд бүртгэлийн шаардлага тавих⁸ зохицуулалт бий. Энэ нь Монгол Улсад гэрлэлтийн гэрээг бүртгэлийн тогтолцоотой холбох хэрэгцээг харуулж байна.

Эдгээр улсуудын туршлагаас харахад гэрлэлтийн гэрээний институт нь гурван нийтлэг тулгууртай байна. Үүнд: нэгдүгээрт, гэрээний агуулгыг ихэвчлэн эд хөрөнгийн харилцаанд хязгаарлах; хоёрдугаарт, хэлбэрийн тусгай шаардлага

⁸ Republic of Korea Civil Act, Article 829.

буюу нотариат, бичгээр байгуулах, бүртгэх; гуравдугаарт, гуравдагч этгээдийн оролцоо болон эдийн засаг эрх зүйн байдал сул талын хамгаалалтыг хангах шүүхийн хяналт байхаар зохицуулсан байна.

IV. ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсад гэрлэлтийн гэрээний хэрэгцээ нь зөвхөн салалтын үед хөрөнгө хуваах асуудлаар хязгаарлагдаад зогсохгүй Энэ нь гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг урьдчилан тодорхойлох, бизнесийн болон өрхийн хөрөнгийг ялгах, өр төлбөрийн эрсдэлийг зохицуулах, олон улсын гэрлэлтэд хэрэглэх хуулийг тодруулах, нотолгооны маргааныг багасгах, талуудын санхүүгийн ил тод байдлыг нэмэгдүүлэх цаашлаад эдийн засаг эрх зүйн байдал сул талын эрхийг хамгаалах эрх зүйн хэрэгсэл юм.

Гэсэн хэдий ч гэрлэлтийн гэрээ нь гэр бүлийн эрх зүйн суурь зарчимтай заавал нийцэх ёстой. Тэгш эрх, сайн дурын хүсэл зориг, хүүхдийн эрх ашиг, эдийн засаг эрх зүйн байдал сул талын хамгаалалт, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах баталгаа нь гэрээний эрх чөлөөнөөс давуу үйлчлэх императив хязгаар байх шаардлагатай. Тиймээс гэрлэлтийн гэрээг "өмчөө хамгаалах хэрэгсэл" гэхээс илүү "шударга, урьдчилан тодорхой, хариуцлагатай гэр бүлийн хөрөнгийн зохицуулалтыг тогтоох хэрэгсэл" гэж ойлгох нь зохистой байна. Судалгааны үр дүнг нэгтгэн дараах саналыг дэвшүүлж байна.

1. Нэр томьёо, системийн байрлалыг тодорхой болгох тухай: Гэр бүлийн тухай хуульд "гэрлэлтийн гэрээ" гэх нэр томьёог тодорхойлж, түүнийг гэрлэгчид гэрлэхээс өмнө эсхүл гэрлэлтийн явцад эд хөрөнгийн харилцаагаа хуульд нийцүүлэн тогтоох, өөрчлөх зорилгоор бичгээр байгуулсан хэлцэл гэж тодорхойлох боломжтой. Гэрээний эрх зүйн ерөнхий хүчин төгөлдөр байдал, хүсэл зоригийн дутагдал, хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаврыг Иргэний хуульд, харин гэр бүлийн тусгай хязгаар, хүүхдийн эрх ашиг, тэгш эрхийн хамгаалалтыг Гэр бүлийн тухай хуульд тусгах нь системийн хувьд зохистой. Одоогийн Гэр бүлийн тухай хууль гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцвол гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээ хүчин төгөлдөр бус байх, гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг Иргэний хуулиар зохицуулах тухай заасан. Энэ нь "эд хөрөнгийн гэрээ" гэх ойлголт бүрэн үгүй биш боловч түүний хэлбэр, агуулга, бүртгэл хангалттай хөгжөөгүйг харуулна. Иймээс гэрлэлтийн гэрээг тусгайлан хуульчлахдаа Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль, Улсын бүртгэлийн багц хууль, Нотариатын тухай хуультай уялдуулах хэрэгтэй.

2. Хэлбэр, нотариат, бүртгэлийн шаардлагын тухай: Гэрлэлтийн гэрээг бичгээр байгуулж, нотариатаар гэрчлүүлэхийг заавал шаардлага болгох нь зүйтэй. Нотариатын үндсэн үүрэг нь зөвхөн гарын үсэг баталгаажуулах бус, талуудад гэрээний үр дагаврыг тайлбарлах, хүсэл зориг чөлөөтэй эсэхийг шалгах, хэлцлийн агуулга хуульд харш эсэхийг урьдчилан хянахад оршино. Энэ нь ялангуяа гэрлэхээс өмнө эдийн засгийн хувьд тэнцвэргүй талуудын хамгаалалтад чухал.

Гэрлэлтийн гэрээг гэрлэлтийн улсын бүртгэл болон эд хөрөнгийн улсын бүртгэлтэй уялдуулах шаардлагатай. Талуудын хооронд гэрээ хүчин төгөлдөр



байх нөхцөл, гуравдагч этгээдэд эсэргүүцэх нөхцөлийг ялгах нь зүйтэй. Жишээлбэл гэрээ нотариатаар гэрчлэгдсэнээр гэрлэгчдийн хооронд хүчинтэй, харин үл хөдлөх хөрөнгө, барьцаа, компанийн хувьцаа зэрэг гуравдагч этгээдийн эрхийг хөндөх хэсэг нь холбогдох бүртгэлд тэмдэглэгдсэнээр гуравдагч этгээдэд эсэргүүцэх боломжтой байхаар зохицуулж болно.

3. Гэрлэлтийн гэрээний чөлөөт байдлын тухайд: Хуульд хүчин төгөлдөр бус нөхцөлийн нээлттэй болон хаалттай жагсаалт хослуулах нь зүйтэй. Хүүхдийн тэтгэлэг, хүүхдийн асрамжийн асуудлыг хүүхдийн эрх ашигт харш урьдчилан шийдэх; гэр бүлийн хүчирхийллийн улмаас эрхээ хамгаалуулах боломжийг хязгаарлах; нэг талын хөдөлмөр эрхлэх, суралцах, эмнэлгийн тусламж авах, гэр бүлээс гадуурх нийгмийн харилцаанд оролцох эрхийг хязгаарлах; гэрлэгчийг амьжиргааны эх үүсвэргүй үлдээх; хуулиар хамгаалагдсан тэтгэмж, нөхөн төлбөрөөс бүрэн татгалзуулах нөхцөлийг хүчин төгөлдөр бус гэж тодорхой тусгах шаардлагатай.

Шүүх гэрээний хүчин төгөлдөр байдлыг шалгахдаа дараах шалгуурыг ашиглаж болох юм. Үүнд: талуудын нас, боловсрол, хэлний ойлголт, эрх зүйн зөвлөгөө авсан эсэхийг; хөрөнгө, өр төлбөрийн мэдээлэл бүрэн ил болсон эсэх; гэрээ байгуулах хугацаа гэрлэлтийн бүртгэлээс хангалттай өмнө байсан эсэх; нэг талын эдийн засгийн хараат байдал, хүчирхийлэл, дарамт байсан эсэх; гэрээ хэрэгжих үед хүүхэд, хөдөлмөрийн чадвар, амьжиргаанд үзүүлэх үр дагавар зэрэг.

4. Иргэдэд ойлгомжтой загвар, бүртгэлийн мэдээллийн хамгаалалтын тухайд: Төрөөс гэрлэлтийн гэрээний зөвлөмж загвар, тайлбар хуудсыг боловсруулж, нотариат, улсын бүртгэл, шүүхийн байгууллага хооронд нэгдсэн ойлголт бий болгох хэрэгтэй. Энэ нь гэрээг зөвхөн өндөр орлоготой хүмүүсийн хэрэгсэл бус, иргэдийн өмчийн аюулгүй байдал, гэр бүлийн санхүүгийн ил тод байдлыг дэмжих нийтлэг эрх зүйн хэрэгсэл болгоно.

Бүртгэлийн ил тод байдал болон хувийн мэдээллийн хамгаалалтын тэнцвэрийг хангах шаардлагатай. Гэрлэлтийн гэрээний бүх агуулгыг нийтэд нээлттэй болгох нь хувийн амьдралд халдах эрсдэлтэй. Харин гуравдагч этгээдийн эрхтэй холбоотой үндсэн мэдээлэл, тухайлбал үл хөдлөх хөрөнгийн өмчлөл, барьцаа, хувьцааны эзэмшилд нөлөөлөх заалтыг л холбогдох бүртгэлд тэмдэглэж, гэрээний бүрэн эхийг зөвхөн эрх бүхий этгээд, шүүх, нотариат, талууд үзэхээр зохицуулж болно.



НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль, 1999 он.
2. Монгол Улсын Иргэний хууль, 2002 он.

2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Гэр бүлийн эрх зүйн судалгаа 2024
2. Харьцуулсан эрх зүйн судалгааны эмхэтгэл. УБ, 2023.

3. Гадаад хэл дээрх эх сурвалж:

1. Uniform Premarital Agreement Act (UPAA), United States.
2. Mnookin, R., Kornhauser, L. (2020). *Family Law and Practice*. New York: Aspen Publishers.
3. Alexy, Lennart; Fisahn, Andreas; Hähnchen, Susanne; Mushoff, Tobias; Trepte, Uwe. Das Rechtslexikon. Begriffe, Grundlagen, Zusammenhänge. 2. Auflage. Bonn: J.H.W. Dietz Nachf., 2023.
4. Posner, R. A. (2014). *Economic Analysis of Law* (9th ed.). New York: Wolters Kluwer.
5. Atwood, B. (2021). *Modern Family Property Law*. Oxford: Oxford University Press.
6. Schwenzer, I. (2016). *Family Law in a European Perspective*. Cambridge: Intersentia.
7. Ellman, I. M. (2019). "The Place of Prenuptial Agreements in Family Law". *Family Law Quarterly*, 53(2).
8. Marston, J. (2021). "Fairness and Autonomy in Prenuptial Agreements". *International Journal of Law, Policy and the Family*, 35(1).
9. Scott, E. S. (2018). "Marriage, Contracts, and Private Ordering". *Virginia Law Review*, 104(3).
10. Singer, J. (2020). "Comparative Matrimonial Property Regimes". *American Journal of Comparative Law*, 68(4).
11. Chen-Wishart, M. (2019). "Contractual Fairness in Family Agreements". *Oxford Journal of Legal Studies*, 39(4).
12. German Civil Code (Bürgerliches Gesetzbuch, BGB).
13. Japanese Civil Code (Act No. 89 of 1896).
14. Carbonnier, J. (2018). *Droit Civil: La Famille*. Paris: Presses Universitaires de France.

4. Цахим эх сурвалж:

1. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагын цахим хуудас: <https://www.unwomen.org>.
2. Олон Улсын хувийн эрх зүйн Гаагийн бага хурлын цахим хуудас: <https://www.hcch.net>.
3. Дэлхийн банкны цахим хуудас: <https://www.worldbank.org>.
4. Корнеллийн эрх зүйн мэдээллийн хүрээлэн: <https://www.law.cornell.edu>.
5. Оксфордын их сургуулийн хэвлэлийн газрын цахим хуудас: <https://global.oup.com>.



Article

Хүний эрх, эрх зүй, гэрлэлт, гэрлэлтийн гэрээ, гэрлэлтийн гэрээний гэрээ

Legal standards and requirements of marital agreements: Comparative analysis of selected foreign jurisdictions

VANCHIGMAA Munkhbayar*

Abstract: This article examines the legal nature of prenuptial and marital agreements, the essential legal requirements imposed on such agreements, and selected foreign legal experiences in comparative perspective. The study analyzes the current legal framework of Mongolia concerning marital agreements and compares it with the legal regulations and judicial practices of Germany, the United States, Japan, and France. Particular attention is given to the validity requirements of marital agreements, including voluntary consent, legal capacity, fairness, disclosure obligations, notarization, and the protection of third-party interests. The research demonstrates that developed legal systems generally recognize contractual freedom in marital relations while simultaneously imposing limitations to protect public policy, children's rights, and economically vulnerable spouses. Comparative analysis reveals that transparency of financial information, procedural fairness, and judicial review mechanisms are central elements in determining the enforceability of marital agreements.

The article further identifies several practical and doctrinal challenges within the Mongolian legal system, including limited public awareness, inconsistent judicial practice, insufficient regulation concerning third-party rights, and the lack of standardized contractual models. Based on comparative legal analysis, the study proposes recommendations aimed at improving Mongolia's legal framework governing marital agreements and strengthening preventive legal mechanisms in family law disputes.

Keywords: Prenuptial Agreement, Marital Agreement; Family Law, Comparative Law, Property Relations, Contractual Freedom, Validity Requirements, Matrimonial Property Regime, Judicial Practice, Mongolia.

* Senior lecturer of Private law department, School of law, University of Internal Affairs, Doctor of Laws (Ph.D).